



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 552

Улаанбаатар хот

“Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн
газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 9 дэх хэсэг, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхай ашиглалтад орж байгаатай холбогдуулан “Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэрийн ажиллагсдын тоог 185 хүнээр нэмэгдүүлж, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны дээд хязгаарыг 1789 (нэг мянга долоон зуун наян ес) байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 610 дугаар тогтоолын 3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132906919

\Huraldaanii material\2021 on\2021.12.02 20-r huraldaan.docx